



Сэдэв: Инкотермсийн дүрэм, нөхцөлүүд




- ✧ Гадаад худалдаа, арилжааны үйл ажиллагаа нь худалдагч, худалдан авагч гэсэн зөвхөн 2 талын оролцоотой явдаггүй.
- ✧ Талуудын хооронд хийсэн хэлцэл, арилжаа, худалдааг дундын үйлчилгээ үзүүлэгч нар талуудтай нэмэлт гэрээ хийж холбодог. Нэмэлт гэрээгээр бараа бүтээгдэхүүний хүргэлт, хадгалалт, ачилт, буулгалт, даатгал, төлбөр тооцоо, баримт бичгийн бүрдүүлэлт гэх мэт үйлчилгээ хийгдэнэ.
- ✧ Нэмэлт гэрээгээр хийгдэх энэхүү үйлчилгээний давуу талууд:
 - гадаад худалдааг олон улсын хэмжээнд нэгдсэн дүрэм, жишиг, ойлголцлоор явуулах;
 - худалдааны үйл ажиллагааг хялбарчлах, түргэтгэх, цаг хугацаа хэмнэх;
 - худалдагч болон худалдан авагч нарын хүлээх эрсдэл, зардал, үүрэг хариуцлагыг тодорхойлох;
 - бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, төлбөр тооцоог шуурхай хийх, талуудын хооронд үүсдэг үүрэг, харилцааг хөндлөнгийн байр сууринаас зохицуулах.



Бараа бүтээгдэхүүний хүргэлт




- Олон улсын хэмжээнд гадаад худалдааны салбарт ашиглагддаг **НЭМЭЛТ гэрээнүүдийн** нэг хэлбэр нь **Инкотермс** буюу Incoterms (International Commercial Terms) үгчилбэл Олон улсын арилжааны нөхцөлүүд юм.
- Инкотермсийг 1936 оноос эхлэн **Олон Улсын Худалдааны Танхимаас** боловсруулан гаргаж эхэлсэн.
 - **Олон Худалдааны Танхим 1919 онд Парис хотод байгуулагдсан.**
 - **Дэлхийн 120 гаруй орон хамрагддаг.**
 - **Дэлхийн Худалдааны Байгууллага, НҮБ болон тэргүүлэх 20 орны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн.**
- **Олон Улсын Худалдааны Танхим** нийт 6 удаа **Инкотермсийг** шинэчлэн баталсан. Хамгийн сүүлд шинэчлэгдэн батлагдсан хувилбар нь **Инкотермс 2010**.




Инкотермс нь “**бараа, бүтээгдэхүүний хүргэлт**” дээр үүсдэг дараах 3 багц асуудлыг шийдэхэд худалдагч болон худалдан авагч талууд ямар байр сууринаас оролцохыг зохицуулдаг дүрэм:

- ① *Бараа, бүтээгдэхүүнийг худалдагчаас худалдан авагч руу тээвэрлэж хүргэх;*
- ② *Бараа, бүтээгдэхүүний экспорт, импортын үзлэг шалгалт, гааль;*
- ③ *Бараа, бүтээгдэхүүний хүргэлтийн үед талуудын хүлээх эрсдэл, үүрэг хариуцлага, зардал.*



Инкотермс нь дараах зохицуулалтыг хийдэггүй:

- ① *Инкотермс нь хууль биш дүрэм. Талууд өөрсдийн хийсэн худалдааны гэрээгээ үндэс болгож инкотермсийн тохирох нөхцөлүүдийг ашигладаг.*
- ② *Инкотермсийн нөхцөлүүдээс давсан эсвэл зохицуулагдахгүй тийм харилцаа, нөхцөл байдлыг талууд худалдааны гэрээндээ тусгах шаардлагатай.*
- ③ *Бараа, бүтээгдэхүүний өмчлөлийг нэгээс нөгөөд шилжүүлэх харилцааг зохицуулахгүй.*
- ④ *Урьдчилан таамаглаагүй, гэнэтийн үйл явдлаас үүсэлтэй өр төлбөр, үүрэг хариуцлагаас аль нэг талыг чөлөөлөх хэрэгсэл биш.*
- ⑤ *Талууд худалдааны гэрээгээ зөрчсөнөөс үүдэлтэй ямар нэгэн үр дагаврыг зохицуулахгүй.*




Инкотермс нь 3 үсгээр товчлон нэрлэгдсэн 11 төрлийн нөхцөлүүдтэй.

Бүх төрлийн тээвэрт 7 нөхцөлийг, харин далайн болоод дотоодын усан тээвэрт 4 нөхцөлийг ашигладаг.

Бүх төрлийн тээвэр							Далайн болон дотоодын усан тээвэр			
EXW	FCA	CPT	CIP	DAT	DAP	DDP	FAS	FOB	CFR	CIF
Ex Works	Free Carrier	Carriage Paid to	Carriage & Insurance Paid to	Delivered at Terminal	Delivered at Place	Delivered Duty Paid	Free Alongside Ship	Free on Board	Cost & Freight	Cost, Insurance & Freight
Худалдагчийн нэрлэсэн газарт хүргэх	Тээвэрлэгч хүргэх	...хүртэл тээвэрлэлт төлөгдсөн	Нэрлэсэн газар даатгал, тээвэрлэлт төлөгдсөн	Терминалд хүргэх	Нэрлэсэн газарт хүргэх	Хүргэлтийг бүрэн төлж хүргэх	Ачаалах боомтын тавцанд хүргэх	Усан онгоцны тавцанд хүргэх	Очих боомт хүртэл зардал, тээвэрлэлтийг төлсөн	Очих боомт хүртэл зардал, тээвэрлэлт, даатгалыг төлсөн

Инкотермсийн ямар нөхцөлийг сонгосноос хамаарч талуудын хүлээх үүрэг хариуцлага хүргэлтийн үе шатуудад өөр өөр байдаг. Хүлээх үүргийн дагуу талуудын хариуцах дамжлага, үүрэг, төлөх зардал, хүлээх эрсдэлүүд нь өөр хоорондоо ялгаатай.

ИНКОТЕРМС 2010 ДҮРМИЙН НӨХЦӨЛҮҮДИЙН ЗУРАГЛАЛ



Инкотермс 2010 дүрмийн нөхцөлүүдийг 4 хэлбэрт ангилдаг

Ангилал	Нөхцөлүүд		
E-Ачигдсан	EXW	Ex Works	Худалдагчийн нэрлэсэн газарт хүргэх
F-Үндсэн тээвэрлэлт төлөгдөөгүй	FCA	Free Carrier	Тээвэрлэгч рүү хүргэх
	FAS	Free Alongside Ship	Ачаалах боомтын тавцанд хүргэх
	FOB	Free On Board	Усанд онгоцны тавцанд хүргэх
C-Үндсэн тээвэрлэлт төлөгдсөн	CPT	Carriage Paid To	...хүртэл тээвэрлэлт төлөгдсөн
	CIP	Carriage and Insurance Paid To	Нэрлэсэн газарт хүртэл тээвэрлэлт, даатгал төлөгдсөн
	CFR	Cost and Freight	Очих боомт хүртэл зардал, тээвэрлэлтийг төлсөн
	CIF	Cost, Insurance and Freight	Очих боомт хүртэл зардал, тээвэрлэлт, даатгалыг төлсөн
D-Тодорхой газар хүртэл хүргэлт хийсэн	DAT	Delivered At Terminal	Терминалд дээр хүргэх
	DAP	Delivered At Place	Нэрлэсэн газарт хүргэх
	DDP	Delivered Duty Paid	Хүргэлтийг бүрэн төлж хүргэх



Бүх 11 нөхцөл тус бүр дээр худалдагч болон худалдан авагч талууд нь өөр хоорондоо ялгаатай 10 төрлийн үүрэг, эрсдэл, зардлыг хариуцдаг.

Худалдагчийн Хүлээх Үүрэг Хариуцлага, эрсдэл, Зардал (А)	Худалдан Авагчийн Хүлээх Үүрэг Хариуцлага, эрсдэл, Зардал (Б)
А.1. Худалдагчийн Ерөнхий Үүрэг	Б.1. Худалдан Авагчийн Ерөнхий Үүрэг
А.2. Лиценз, Зөвшөөрлүүд, Хилээр Чаа, Бараа оруулах Шаардлагууд, Таалийн Бүрдүүлэлт болон Бусад Журмууд	Б.2. Лиценз, Зөвшөөрлүүд, Хилээр Чаа, Бараа оруулах Шаардлагууд, Таалийн Бүрдүүлэлт болон Бусад Журмууд
А.3. Тээвэрлэлт болон Даатгалын Тэрээнүүд	Б.3. Тээвэрлэлт болон Даатгалын Тэрээнүүд
А.4. Жүргэлт	Б.4. Жүргэлтийг Хүлээн Авах
А.5. Эрсдэл Шилжих	Б.5. Эрсдэл Шилжих
А.6. Зардлын Хуваарилалт	Б.6. Зардлын Хуваарилалт
А.7. Худалдан Авагч Талд Мэдэгдэх	Б.7. Худалдагч Талд Мэдэгдэх
А.8. Жүргэлтийн Баримт Бичиг	Б.8. Жүргэлтийг Хүлээн Авсан Нотолгоо
А.9. Хянах, Савлах, Тэмдэглэгээ Хийх	Б.9. Бараа, Бүтээгдэхүүний Үзлэг
А.10. Мэдээлэл Өлох болон Түүнтэй Холбоотой зардлуудад Туслалцаа Үзүүлэх	Б.10. Мэдээлэл Өлох болон Түүнтэй Холбоотой зардлуудад Туслалцаа Үзүүлэх

ИНКОТЕРМС 2010 ДҮРМИЙН НӨХЦӨЛҮҮДИЙН ЯЛГАА



Худалдагч

Худалдан авагч

Талуудын хүлээх үүрэг, төлбөр, хариуцлага, үрсдэл	Бүх төрлийн тээвэр							Далайн болон дотоодын усан			
	EXW	FCA	CPT	CIP	DAT	DAP	DDP	FAS	FOB	CFR	CIF
Зардлын харьцуулсан хэмжээ	\$	\$\$	\$\$\$	\$\$\$	\$\$\$\$	\$\$\$\$	\$\$\$\$\$	\$\$	\$\$	\$\$\$	\$\$\$
Барааны баглаа боодол	Худалдагч							Худалдан авагч			
Барааны гэмдэглэгээ, шошго	Худалдагч							Худалдан авагч			
Экспортын зөвшөөрөл	Худалдагч							Худалдан авагч			
Ачаа дамжуулагчийн төлбөр	Худалдагч							Худалдан авагч			
Үндсэн тээвэрлэгч рүү хүргэх	Худалдагч							Худалдан авагч			
Үндсэн терминалын хураамж	Худалдагч							Худалдан авагч			
Усан онгоцонд ачуулах хураамж	Худалдагч							Худалдан авагч			
Усан тээвэр/гаарын тээвэр	Худалдагч							Худалдан авагч			
Экспортын барааг дамжуулагчийг сонгох	Худалдагч							Худалдан авагч			
Далайн даатгал	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Үндсэн тээвэрлэгчээс ачааг буулгах хураамж	Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө. Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө.							Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө.			
Очих газрын терминалын хураамж	Төлбөрийн жшигээс хамаарч аль нэг тал нь төлнө.							Төлбөрийн жшигээс хамаарч аль нэг тал нь төлнө.			
Тээвэрлэгчийг сонгох	Худалдагч							Худалдан авагч			
Хилээр зорх шаардлагууд	Худалдагч							Худалдан авагч			
Гаалийн үзлэг шалгалтын төлбөр	Худалдагч							Худалдан авагч			
Гаалийн хураамж, татвар	Худалдагч							Худалдан авагч			
Худалдан авагч рүү хүргэх	Төлбөрийн жшигээс хамаарч аль нэг тал нь төлнө.							Худалдан авагч			
Ачааг буулгах	Худалдагч							Худалдан авагч			

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

